



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/364

Улаанбаатар хот

Сургууль, цэцэрлэгийн бүтэц, орон тоог
судлах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн төрийн өмчийн сургууль, цэцэрлэгүүдийг батлагдсан орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг судалж, шинээр байгуулагдсан болон бүлэг нэмэгдсэн сургууль, цэцэрлэгүүдийн орон тооны хязгаарыг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бүтэц, орон тоог судлан тогтоож, 2017 оны 11 дүгээр сарын 15-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн дарга Д.Уламбаярт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ